

БАРУУН ИЛГЭНИЙ ЭРТНИЙ БИЧЭЭС

Ц.БАТТУЛГА¹, Г.БАДАМСАМБУУ², Б.БАТЖАРГАЛ³

¹МУИС, ШУС, Ази судлалын тэнхим, Түрэг судлалын салбар,
e-mail: ts_battulga@yahoo.com; centreturkicamongol@yahoo.com

²МҮОНРТВ, Судлаач, e-mail: badmas.ge@gmail.com

³МУИС, Хүмүүнлэгийн салбар, докторант, e-mail: ulaanzalaat@qq.com

ТҮЛХҮҮР ҮГС: Дундговь аймаг, Дэлгэрхангай сум, Инэл (Дэлгэрхангай) уул, Баруун илгэн, эртний хятад бичээс

ТОВЧ АГУУЛГА: Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутаг Инэл буюу Дэлгэрхангай уулын баруун өмнө Баруун илгэнд (Өнөөдөр нутгийн хүмүүс Хүрэн хайрхан уул гэж нэрлэх болсон) эртний хятад бичээс байсныг 2001 онд Монголын Үндэсний телевизийн “Аяллын цаг” нэвтрүүлгээр анх олон нийтэд мэдээлсэн ажээ.

Түүнээс хойш цөөнгүй эрдэмтэд үзэж судалсан мэдээ буй боловч уншиж тайлсан судалгаа өнөө хэр хараахан үгүй бололтой. Тиймээс бид 2016 оны 6-р сарын 24-26-нд уг бичээсийг хуулбарлан авч дахин нягталж судалсан болно.

Энэхүү өгүүлэлдээ хээрийн шинжилгээний ангийн ажлын зарим үр дүнгээс, тухайлбал Хүннү хийгээд Хан улсын түүхийн чухаг сурвалж болох бичээсийн хэв дардас, гэрэл зураг, бичлэг зэрэг эх хэрэглэгдэхүүний баримтыг сурвалжийн мэдээ сэлттэй харьцуулж, улмаар уг судалгаандаа тулгуурлан бичээсийг монгол хэлнээ орчуулсан орчуулга, товч тайлбар, холбогдох түүхэн мэдээ, мөн Янь Рань буюу Инэл уул орчмын газарзүйн онцлог, нэрийн талаар товч авч үзсэн болно.

Баруун илгэний хаднаа сийлсэн уг эртний бичээс нийтийн тооллын 89-91 онуудад Хан улсын цэрэг Хүннүг довтолсон түүхэн үйл явдлын нотолгоо болж буйн хувьд чухал ач холбогдолтой. Янь Рань (Инэл буюу Дэлгэрхангай) уулыг Хан улсын цэрэг тахиж, ялалтын алдраа хаданд ийнхүү сийлж мөнхжүүлсэн нь эртний архивын нэгэн бичмэл сурвалжтай үг үсгээр тохирч, тэдгээрийг харгуулан тайлах өвөрмөц боломжийг судлаачдад олгож байна. Уг бичээсийн онцлог ба түүхэн гол үнэ цэнэ үүнд оршино.

Дундговь аймгийн Дэлгэрхангай сумын нутагт Дэлгэрхангай (Инэл) уулаас баруун өмнөд хөндий рүү 6 км алсан тасарч тогтсон Баруун илгэн хэмээх толгод өндөрлөг бий. Говь нутгийн ардууд үүнийг Хүрэн хайрхан уул гэдэг. Энэхүү Баруун илгэний гол өндөрлөг дээр өмнө зүг хандсан мөргөцөг хэлбэртэй эгц хадан хясаанд эртний хятад бичээс буй. Уг хадны бичээсийг малчдын өгсөн мэдээгээр Монголын үндэсний телевизийн сэтгүүлч Г.Бадамсамбуу 2001 оны 06 сарын 27-нд анх сурвалжлан очихдоо Дэлгэрхангай сумын засаг дарга Д.Бямбаагаар газарчлуулжээ. Олон нийтэд

мэдээлэгдсэнээс хойш 2002 оноос доктор С.Чулуун (тэр үед ОХУ-д оюутан байв), 2016 онд доктор Ц.Баттулга нарын зэрэг судлаачид Баруун илгэнд гадаад, дотоодын судлаачдыг авч очихдоо тухай бүр сэтгүүлчээс байршлыг лавлаж заалгаж байжээ. Баруун илгэний байршил нь газарзүйн хувьд өнөөгийн Монгол орны өмнөд төв хэсгийн говь цөл ба цөлөрхөг хээрийн заагт оршино. Үүнийг уламжлалт ойлголтоор “говийн ар” буюу хээрийн бүсэд нэвтрэхийн өмнөд зах гэж үзэж болно. Хожуу үеэс эндэх том уулын нэрийг “Дэлгэрхангай” буюу “баялаг сайхан хангай нутаг” гэх нэрээр сольж говь нутгийнхан

өргөмжлөн дуудах болсон бололтой бөгөөд угтаа энэ нутаг нь хангайн бүсэд хамаарахгүй, харин говьд тооцогдох хэв шинжит газар мөн.

Газарзүйн онцлог, нэршил, байрлал, түүхэн ач холбогдлын тухай

Говь, хээрийн бүсийн заагт орших Баруун илгэн нь ($43^{\circ}10'54.34''N$, $104^{\circ}33'17.19''E$) солбицолд, 4.42 км хавтгай дөрвөлжин талбайг (1.7 x 2.6 км) эзэлж, энэ орчмын голлох уулсын тогтолцооноос говирхог хөндий тийш тасарч тогтсон (илхэн үзэгдэх), мөн булаг шанд, сайр жалга бүхий эргэн тойрны нөхцөлтэй байна¹. Өндөрлөг хэсгээрээ улаан хүрэн боржин чулуун судал, намхан цохио, хясаанаас тогтжээ. Энэхүү хадархаг толгодын хамгийн өндөр цэг болох эртний бичээс бүхий өндөрлөг нь д.т.д 1480 метрээр хэмжигдэнэ. Намхан хэдий боловч эндээс эргэн тойрны говийн уулс, хөндий бүрнээ илхэн үзэгдэх харууцтай ажээ. Баруун илгэний харьцангуй өндөр (бэлээс орой хүрэх өндөр) нь дунджаар 40 метр (өмнөд бэлээс 70 м, хойд бэлээс 32 м) юм. Хадат өндөрлөгүүдийн чуулбар болох тул толгод хэлбэрт бэсрэг уул гэж нэрлэж ч болох талтай.

Түүхэн сурвалжаас үзвэл, өнөөгийн Дэлгэрхангай уулын уг нэрийг Инэл уул гэдэг байжээ. Үүнийг батлах хуучин газрын зургийн баримтууд бий. Жишээ нь, Түшээт хан аймгийн 1805 оны, мөн тус аймгийн Түшээ гүн Чагдаржавын хошууны 1907 оны хуучин газрын зургуудад уг уулыг “Инэл уул” гэж тэмдэглэжээ. 1925 онд Оросын судлаач А.Д.Симуков (Шар Дамдинсүрэн) БНМАУ-ын газрын зураг зохиохдоо “Дэлгэрхангай (Инэл)” хэмээн уг хоёр нэр нь нэг уулынх болохыг тод үлдээжээ. Нилээд эртний мэдээ гэвэл, Манжийн Энх-амгалан хааны зарлигаар бүтсэн 《皇輿全览图》(1708-1718) газрын зурагт 衣尼儿山 Yī ní er shān (Еинал уул буюу Еиниэр уул) гэжээ. Энэ мэт хуучин, шинэ нэрийн талаарх мэдээ цөөнгүй нэмж илрэх боломжтой байна².

Нутгийн домог яриагаар бол XVI зууны төгсгөлд Халхын Автай сайн хаан “Дэлгэрхангай” хэмээх шинэ нэрийг Инэл ууланд хайрлажээ гэдэг.

Оросын судлаач П.К.Козловын 1899-1901 оны аяллын маршрут зураглалд (Центральная гоби по съёмк П.К.Козлова) “г.Дэлгэр-хангай” хэмээх уг уулыг Хангийн даваагаар (Пер. Ханги) давж өмнөш уруудах хэсэгт “кол.Илигынъ” гэж тэмдэглэсэн нь бидний өгүүлэн буй Баруун илгэний худгийг заажээ. Үүнээс өмнө 1890 онд Хаант Оросын “Карта Азиатской Россіи и Смежныхъ съ нею владѣній...” хэмээх газрын зурагт энэ орчныг “кол.Елгинэ” (Елгин худаг) гэж тэмдэглэсэн байна. Бас З.Л.Матусовскийн (1889 он) газрын зурагт “Кум.Илегэинь-хураль” гэх нэрийг дээрхтэй адил баримжаанд тэмдэглэсэн бол монгол хошуу нутгийн зургийн “Илгэн хурал” хэмээсэн нэр, байршил үүнд дүйж байна. Эдгээр газар орчин нь “Түшээ гүн Ча-гийн суух албан гэр” хэмээн өргөө гэр зурж заасан хуучин хошууны өөр зургийн мэдээлэлтэй үндсэндээ бас тохирдог. Хожим Баруун илгэний зүүнд “Шохойт” нэрт сумын төв XX зууны эхээр түр суурьшиж байв. Тэгэхээр Баруун илгэний ус булаг, худгийг бараадаж нутагших явдал байсан ба аян зам дайран өнгөрөх орчин байжээ. Мөн Инэл уул ба Илгэн худаг гэдэг нэр нь хуучны гол нэр болохыг эдгээр мэдээнүүд баталж буй.

Инэл уул нь говийн их замын төгсгөл, говь, тал хээрийн бүсийг зааглах, ганцаар алсалсан багавтар нуруу бөгөөд говь туулж ирэгсдийн хувьд өвс ургамал, ан амьтан ихтэй, булаг, ус худаг элбэг дэлбэг, үнэхээр дэлгэр сайхан газар нутаг болохыг нэмж сануулах юун билээ. Хуучин хошуу нутгийн газрын зурагт Инэл уулаас өмнөш дэвсгэр өнгийг улбар (говийн өнгө), умарш дэвсгэр өнгийг ногооноор (өвсөрхөг ногоон хээрийн өнгөөр) ялгаж тэмдэглэсэн нь өнөөгийн газарзүйн хэв шинжтэй тохирно. Баруун илгэн бол Инэл уулын тогтолцоонд хамаарах салбар өндөрлөг мөн. Харин Инэл (Дэлгэрхангай) уул нь өөрөө мөн л говийн гүнд алсарч тогтсон багавтар нуруу (ойролцоогоор 6 км өргөнтэй 50 км урт үргэлжилнэ) юм. Эндээс Монгол орны томоохон уул нуруудын тогтолцоо (Хангай, Алтай, Хэнтийн салбар уулс) хүртэл 200 гаруй км алсална. Бас эндээс Монголын

¹ Дундговь аймгийн Дэлгэрхаан сумын Тарган баг буюу II багийн нутагт буй бөгөөд эндээс зүүнш аймгийн төв Мандалговь хот 180 км, Дэлгэрхангай сумын төв 23 км зайтай.

² Atlas of China Jean Baptiste D'Anville A-1-49-29 Kalkas. 1732. L.Brown Collection; мн Cary, John, A new map of

Chinese and Independent Tartary. 1806. New universal atlas 1808: Эдгээр газрын зурагт тухайн уулыг “Inil” гэж тэмдэглэв.

сонгодог хээрийн бэлчээрт хүрэхэд 150 орчим км умарш нэвтрэх шаардлагатай. Инэл уулын баруун талаар Онгийн хөндий үргэлжилнэ. Уг уулаас 30 км-т Монголын говийн хамгийн том Онги гол урсан өнгөрөх тул ингэж нэрлэжээ.

Мөн түүнчлэн говь туулах их өртөө зам буюу “говийг туулах коридор” энэ бүс нутгаар дайрч өнгөрдөг байсан нь түүх бичгүүд болон хуучны газрын зургаас тодорхой байдаг. Манжийн үеэс “Алтайн өрнө замын цэргийн өртөө” гэх стратегийн чиглэл болон Онгийн хөндийг өгсөж Монголын хээр тал руу умарш нэвтрэх гол ба туслах замууд (цэрэг, худалдаа, шуудангийн замууд) эртний уламжлал даган энэ бүс нутгаар дамжин өнгөрч байжээ.

Инэл уулын нэр чухам хэдүйгээс Дэлгэрхангай нэртэй болсон талаар тодорхой баримт бид хараахан олж үзсэнгүй. Дамцагдоржийн зохиосон “Их газрын эзэн Дэлгэрхангай уулын сан тахилга тус амгалангийн хурыг буулгагч” хэмээх сударт уулыг тахигдаа баатар хүний хөө хуяг, илд мэс, эрхэм хvний хувцас чимэг, суудал ширээ, хэрэгсэл зэргийг өргөдөг байсан тухай мэдээ буй нь нэн сонирхолтой. Энэ нь Инэл уулнаа цэрэг дайны томоохон чухал үйл явдал болж өнгөрснийг илтгэхээс гадна нөгөө талаар Инэл уулыг анх цэрэг дайны зорилгоор тахиж байсны ул мөр хэмээн үзэж болох юм. Инэл уулын өвөр бэлийн Тэвш уулнаа баатар хүний хэрэгсэл, бунхан олдвор байсан тухай домог хуучийг одоо ч нутгийнхан ярьсаар буй.

Баруун илгэний толгодын зүүнтээ, Инэл уулын зүүн өвөрт Зүүн илгэн гэх газар буй. Үүнээс үзвэл, Баруун илгэн нэрний “баруун” хэмээх тодотгол нь Инэл уулын өвөр дэх тухайн газрын чиг баримжааг заасан үг ажээ. Баруун илгэн нь Инэл (Дэлгэрхангай) уулыг давах Цагаан даваа (хуучин газрын зурагт Ханги даваа)-ны аманд, зам дагуу орших тул түүхийн олон үеийн туршид стратегийн чухал түшиц зам газрын шинжтэй, газрын зурагт “Илгэн” хэмээн тусгайлан заах ач холбогдолтой байсан байж болох юм.

Элгэн, илгэн гэдэг хоёр үг адилхан сонсогдох боловч утгын хувьд ялгаатайг “Монгол хэлний товч тайлбар толь”-д өгсөн уг үгсийн утга илтгэнэ. Толь бичигт “ИЛГЭН (ilgi) мал гөрөөс тэргүүтний зүйлж элдсэн арьс, зүйлсэн тал нь; *илгэн дээл*; хамба илгэ (нарийлан боловсруулж элдээд тусгай хээ гаргаж дармалласан илгэ)” (Цэвэл, 2013, р.426) гэж тэмдэглэсэн бол харин элгэ (элгэн)

гэх үгийн найман утга буйгаас “ЭЛГЭ I (ЭЛГЭН) (elige) 1. Хүн амьтны уушигны дор өрцөд наалдаж тогтсон сөс боловсруулах нэгэн цулын нэр; 2. Хүн амьтны урд буюу өвчүүн тал; элгэндээ наах; элгэндээ тэврэх; юмны дотогш буюу инагш харсан тал; нумны элэг; 3. Эгц, босоо, цавчим; элгэн хад (ханан хад, өндөр цавчим чилгэр хад)” (Цэвэл, 2013, р.426, р. 1207) гэсэн утгыг эшлэв. Илгэн хад, элгэн хад хэмээн бичсэн нь утга холилдох мэт боловч илгэн толигор хад, илхэн харагдах хад, элгэн хүрэн хад гэх мэтээр дүр байдлыг илтгэх ялгаатай утгууд бас байж болно. Баруун илгэнийг бас Хүрэн хайрхан гэдгээс үзвэл “элгэн хүрэн” гэх утгатай байж болох ч хошууны хуучин газрын зурагт “Илгэн” хэмээн бичжээ. Илгэн гэх нь бас илхэн (ileken) гэх үгтэй холбоотой бөгөөд толь бичигт “ИЛХЭН [ileken] улам тодорхой юм; *илхэн мэдэгдэж байгаа хэрэг*; *илхэн үзэгдэх уул*” (Я.Цэвэл, 2013, р. 423) гэж тайлбарласан буй.

Юутай ч түүхэн газарзүйн баримтаас үзвэл, энэхүү бичээс Инэл уулын баруун өмнө бэл дэх Баруун илгэн толгодын оройд (хадан хясаанд, цохионд) үлдсэн нь газрын байршлын ач холбогдолтой уялдах учир буй.

Түүхэн газарзүйн тойм зургуудаас үзвэл, Инэл уулын орчин нь Умард Хүннү гүрний өмнөд хязгаарт хамаарч байжээ. Нүүдэлчдийн голомт нутаг болох Орхон, Туул, Сэлэнгийн сав нутаг эндээс умар зүг 300-500 км, түүнээс цааш үргэлжилнэ (*Хавсралт зураг 1*).

Эртний хятад бичээсийн талаарх товч танилцуулга

Эртний Хан улсын үед холбогдох хятад бичээс нь Баруун илгэний өмнө зүг хандсан өндөрлөгийн 7.6м орчим өндөр боржин хадны элгэнд газраас дээш 3.4м өндөрт сийлэгдсэн бөгөөд хадны гадаргууг 1.3м өргөн, 1м өндөр талбайтайгаар бүхэлд нь тусгайлан засаж тэгшлээд уг бичээсийг 1-2 мм орчим гүн сийлжээ (*Хавсралт зургуудаас үзнэ үү*). Ханзны нүдэлсэн хэмжээ 4х4см, мөр хоорондын зай 2.5-3см, мөрийн өндөр ойролцоогоор 90см, ханзны хоорондох зай 3.5-4.5см болно. Нэг мөрийн дүүргэлт 14 ханз үсэгтэй. Тодруулбал, мөнхүү тооны ханзыг нэг мөрөөр тооцож сийлжээ.

Он цагийн уртад нар салхи, бороо, цасны усанд идэгдсэнээс бичээсийн зүүн дээд хэсгийн зарим ханз бүдгэрч бараг мэдэгдэхгүй болжээ. Гэхдээ гараар тэмтэрч

нилээд ханзны дүрсийг бага боловч сэргээн мэдэх, тогтоох боломжтой ажээ. Уг бичээсийг “Хөшөөн тиг (隶体 lì tǐ)”-ээр хөөн нягталж нэн эртнийх болохыг тогтоож, улмаар цааш нэхэн сурвалжилсаар уг бичээсийн бүрэн эх хувилбар нь Хожуу Хан улсын бичиг, Дөү шянь-ий намтар (23-р ботийн 815 дугаар тал) (后汉书·窦宪传 第03册, 卷23卷; “南朝宋”范晔编撰“唐”李贤等注“后汉书”中华书局出版1965年08月)-т буйг илрүүлсэн юм.

Хаданд нягт нямбай, эмх цэгцтэй сийлсэн энэхүү бичээсийн эхийг цэргийн жанжин, жирийн бичигтэн нэгэн бус, харин ном сударт гийсэн, шаштир түүх туурвиж, эх зохиож дадсан бичгийн их хүн зохиосон нь яруу тансаг найруулгаас тодорхой ажиглагдана.

Түүнчлэн хаданд сийлэгчийн бичгийн ур, сийлэх чадвар тун сайн байсныг хаданд сийлсэн байдал илтгэнэ. Эх зохиогч хаданд өөрөө сийлсэн үү, аль эсвэл хад чулуунд бичиг сийлэх чадварт мэргэжилтэн байсан уу гэдгийг мэдэх аргагүй.

Юутай ч нийтийн тооллын 89-91 оны дайны хэрэг явдлыг хураангуйлж бичсэн гэж үзвэл, бичээсийн эх зохиогч дээрх гурван оны дайн тулааныг маш сайн мэдэхээр барахгүй, өөрийн биеэр оролцож явсан болох нь тодорхой. Гэвч бичээсийн эх зохиогч, бичигчийн талаар өгүүлэхийн өмнө Хүннүгийн төв нутагт хүрч эс чадсан ч дайны ялалтыг “гэрэлт хөшөө”-нд бичиж мөнхжүүлэх санаа сэдэл Янь Рань (Инэл) уулыг эзэлсэнтэй холбоотой гарсан уу, эсвэл ялалт байгуулах газар босгох үүрэгтэй, нэгэнт бэлдсэн эх авч явсан уу гэдгийг бас бодолцож үзэх хэрэгтэй.

Янь Рань уулнаа түүхэн үйл явдлыг тэмдэглэсэн бичээсийг бичих буюу “гэрэлт хөшөө”-ний хад сонгох, газрыг шинжиж тогтоох, хад засаж тэгшлэх, мөр хоорондын зай, ханзны тигийн хэм хэмжээг алдалгүй эхийг зөв хуулж хаднаа сийлэх зэрэг цаг хугацааг тооцож үзвэл, хэдэн хоног байрласан болов уу. Учир нь бичээсийн өглөөний наранд тод харагдаж буй хэсгийг өглөө, оройн наранд сайн харагдаж буй хэсгийг үдийн хойно, орой бичиж сийлсэн гэж үзвэл багагүй цаг хугацаа шаардагдсан нь гарцаагүй. Мөн бичээсийг яарч тэвдэлгүй, өндөр хаднаа ажиллах боломж бүхий чадварлаг хүмүүс нямбай сийлсэн нь илт байна.

Энд Хан улсын цэргийн “удирдах командын байр” байрлаж, цэргийн жанжид, удирдах тушаалтан саатан тухалсан байж болох юм. Газрын байц нь цэргийн “удирдлага” байрлахад тохиромжтой дотроо нуувар, өндрөөс эргэн тойрны харууц бүхий тогтоцтой болохыг өгүүлэх нь илүүц биз ээ.

Бичээсийг сийлэхдээ чухам яагаад Янь Рань уулд болсон тухайн үеийн хамгийн чухал үйл явдлыг дангаар нь тэмдэглэлгүй өмнөх үйл явдлуудыг хамтатган дурдах болов гэсэн асуулт зүй ёсоор гарна. Үүнд:

Нэгд, ялалт байгуулсан газар босгох гэрэлт хөшөөнд зориулж бичээсийн эхийг өмнө нь бэлдсэн байсан,

Хоёрт, өмнөх хоёр жилийн уулгалсан тулаанаас илүү хол, урт замыг туулж, илүү их ялалт гавьяа байгуулснаа илтгэн харуулахын тулд өмнөх үйл явдлыг товч дурдсан,

Гуравт, 89 оны дайныг удирдсан Дөү Шянь жанжин 91 оны үйл хэргийг удирдан зохион байгуулж, өөрийн биеэр оролцоогүй ч алсаас удирдан чиглүүлж байсан тул түүний нэрийг дурдах зайлшгүй шаардлагатай байснаас гадна Дөү Шянь жанжин, Бань Гү нарын хооронд сурвалжид тэмдэглэсэн мэт маш дотно, нарийн харилцаатай байсан зэрэгтэй холбон тайлбарлаж болох юм.

Хан улсын цэрэг Хүннү гүрнийг анх удаа Хө ди-гийн Юун хө-гийн анхдугаар оны 6-р (汉和帝永元元年六月 (公元 89 年)) буюу нийтийн тооллын 89 оны 6-р сард анх удаа, хоёр дахь удаагаа Юун Юаны хоёрдугаар оны 5-р сар (永元二年五月 (公元 90 年)) буюу нийтийн тооллын 90 оны 5-р сард, гурав дахь удаагаа Юун Юаны гуравдугаар оны 2-р сар (永元三年二月 (公元 91 年)) буюу нийтийн тооллын 91 оны 2-р сард тус тус дайлсан байна.

Нийтийн тооллын 91 онд Умард Хүннүгийн хязгаарын Инэл ууланд ирж “Ялалтын хөшөө” босгосноос үзэхэд Хан улсын цэрэг Умард Хүннү нутгийн гүнд Хангай уулнаа хүрч ялалт байгуулсан гэдэг нь үндэслэлгүй, харин говийг туулж, говирхог хээрийн захад хүрээд хөшөөнд тэмдэглэсэнчлэн “тугаа эргүүлж” буцжээ. Үүнийгээ хэт дөвийлгөж умардын домогт Хангай ууланд хүрч ялсан мэтээр бичиж цуурхах болсон бололтой. Ялалт байгуулсан газартаа алдрын гэрэлт хөшөөг сийлж үлдээдэг нь өнө эртний тогтсон ёс, уламжлал болохыг харгалзан үзэх хэрэгтэй.

Магадгүй их цөл говийг туулж ирсэн цэргүүдийн хувьд Инэл (Дэлгэрхангай) уул яах аргагүй хангай мэт сэтгэгдэл төрүүлсэн байхыг үгүйсгэх аргагүй.

Янь Рань бол эртний ялалтаар алдаршсан домогт уул юм. Тиймээс умардыг ялагч хятад эрсийн сүр хүчний дуулал болж үлджээ. Янь Рань уулнаа баатарласан түүхийг дурсаж эртний хятадын үгийн мастерууд олон арван шүлэг найраг бичсэн байдаг. Умардын холхи алсад, зөвхөн ялагч баатар эрс л хүрч чадах уулын тухай төсөөлөл он цаг дамжин ингэж үлджээ.

Янь Рань уул хаа байдаг вэ. Энэ талаар, хятадын үе үеийн түүхчид ч саналаа дэвшүүлсээр иржээ. Тэдгээрээс Сайшаалт Ерөөлтийн үед дахин зассан “Нэгтгэсэн ойллого”-ийн 544 дүгээр бүлэг, “Халх: уулс ус” хэмээх агуулгын дотор Хангай уул гэсэн зурвас тайлбар (清官修《嘉庆重修一通志》卷五四四《喀尔喀·山川》)-т “Хангай бол эртний Янь Рань уул болно” гэж үзсэн буй. Магадгүй энэ үеэс Янь Рань уул бол Хангай юм гэх ойлголт тархсан байж болох юм. Түүнчлэн Чин улсын түүхийн эх ноорог, 78-р бүлэг, газарзүйн ойллого-25-д (《清史稿》卷78, 地理志 25)-д “Хангайг орчуулбаас бөхтэй тэмээ (хоёр бөхтэй) болно. Дүрс нь ойролцоо” гэсэн зүйл ч буй.

Үнэндээ Инэл буюу Дэлгэрхангай уул орчмоос Хангай уулс, Хүннүгийн төв нутагт нэвтэрье гэвэл дахиад наанадаж 300-500 км зам туулах шаардлагатай, хэрвээ явсан бол хүрч очсон тэр газраа энэхүү бичээсийг сийлэх байсан болов уу.

Бичээс сийлэх санаа гэнэт төрөөгүй, аян дайнд мордохдоо Хангайд хүрэх зорилго тавьж даалгавар авсан, тиймээс “Ялалтын гавьяаг тэмдэглэх” хөшөөний эхийг нэгэнт бэлэн болгож, Хангайд хүрч ялалт байгуулсан газар бичих тушаалтай байсан ч хүрээгүй учир өөрсдийн хүрсэн хамгийн эцсийн цэг болох умард Хүннүгийн хил Янь Рань (Инэл) уулнаа бичээс үйлдсэн нь хожим Хангайд хүрсэн мэт эндүүрэл үүсэх шалтгаан болсон байж мэднэ.

Бичээснээ түүхийг өгүүлэхдээ яруу сайхнаар өргөж, уянгын халилыг ихэд ашиглажээ. Яруу магтаал, гоёчилсон шүлгээс гадна “*Мо Ду (Модун)-гийн аймгийг гишгэв. Лао Шангийн луу-гийн ордныг галдав*” гэх зэргээр сүр бадруулж бичсэн нь Дөү Шянь жанжны хэрэг явдалтай холбогдох магадлалтай.

Зүүн Хан улсын хааны хатан нь Дөү Шянь жанжны охин дүү ажээ. Хааны хатны төрсөн ахынх нь хувьд, тухайн үед шоронд хоригдож байсан Дөү Шянь жанжныг шоронгоос суллаж “их гавьяагаар ялыг цайруулах” болзолтойгоор Хүннүгийн эсрэг дайнд мордуулсан түүхтэй. Дөү Шянь-ий амь нас, алдар гавьяа уг дайны ялалт, ялагдлаас шалтгаалж байсан тул тулааны байдлаа хэт дөвийлгөх, заавал ялалтын хөшөө босгож гэрчлэн мандуулах зэрэг онцгой шаардлага байсан гэж үзэх үндэстэй.

Түүхийн үйл явдлыг давуудуулж, хэтийдүүлж бичсэн зүйл Зүүн Хан улсын шаштирт цөөнгүй тааралдах бөгөөд үүний нэг жишээ нь Умард Хүннүгийн шаньютай Алтай ууланд байлдсан гэх хэрэг явдал болно. Товч дурдахад, Янь Рань (Инэл) уул хүртэл цэрэглэхэд оролцож явсан Рен Шаны гавьяа зүтгэлийг үнэлж 92 онд жулланг жан түшмэлийн зэрэглэлд дэвшүүлж шаньюг хянах үүрэгтэйгээр цэрэг авч И У (伊吾 yī wú) хэмээх газар (одоогийн БНХАУ-ын Шинжаан Уйгурын өөртөө засах орны Хами) хүрсэн тухай сурвалжийн мэдээ бий. Бидний өгүүлэн бүхий Янь Рань-ы (Инэлийн) үйл явдлаас даруй дөрвөн жилийн хойно Алтай ууланд байлдсан Рэн Шан (任尚 ren shang) жанжинд зориулан гэрэлт хөшөөг босгохдоо Алтай уулаас алс хол Бархөл нуурын хөвөөнд үлдээснийг хожим олжээ. Ялалтын гэрэлт хөшөө Бархөлөөс олдсон нь Алтайд байлдсан гэх сурвалжийн мэдээг эргэлзээтэй болгодог. Өөрөөр хэлбэл, ялалтын газарт босгодог уламжлалтай “бичээст хөшөө” өөр газраас олдсон нь Зүүн Хан улсын цэрэг Алтайд хүрээгүй, харин Алтайд хүрсэн мэт түүхийг Бархөл нуурын орчимд сийлж орхиод буцсаныг илтгэдэг. Ингэж Янь Рань (Инэл) хүрээд буцсаныг “Хангайд хүрэв” гэж хэтрүүлж ойлгосонтой адил явдал давтагджээ. Хүннүгийн голомтод цөмөрч дайснаа дарсан гэх атлаа тэндээсээ алслан ухарсаар зах нутагт “түмэн үед дуурсгах” алдрын бичээсүүдээ үлдээсэн мэт ойлгогдож байна. Зүүн Хан улсын туйлын зорилго Хүннүгийн гол нутаг Хангайд хүрэх, Алтайд хүрэх байжээ. Гэвч үнэндээ “Ялалтыг тэмдэглэсэн бичээс”-үүдийн газарзүйн байршил нь тэд Хангай, Алтайд хүрч, нүүдэлчдийн гүнд нэвтэрч чадаагүйг л гэрчилж байна.

Дашрамд тэмдэглэхэд, Рен Шангийн хөшөөг 1980 онд Хамигийн Бархөл сумын зүүн өмнө, Бархөл нуурын хөвөөнөөс илрүүлжээ. Хөшөөний магнайд “Хан улсын

харийг төвшитгөсөн хөшөө” гэсэн ханз байснаас сурвалжилж эрдэмтэд уг хөшөөг Зүүн Хан улсын Рен Шангийн хөшөө болохыг тогтоожээ. Хөшөөний бичээс нийт таван мөр, мөр бүрт арван хэдэн ханзтай, хөшөөний бичээс нилээд баларсан учир лавтай уншигдах ханз нь “Хан улсын юаны тавдугаар он. Рен Шан Пу ли (蒲离 pu li) хэмээх нуураас баруун далай хүртэл...” гэх мэт нийт 12 ханз болой.

Хөшөөний бичээс бүрэн бүтэн бус ч “Хожуу хан улсын бичиг” доторх Хө ди-гийн оны цол, Хүннүгийн шаштир, Дөү Шянь-ы намтар зэрэгт Рен Шангийн нэр олонтаа тэмдэглэгдсэн зэрэгт тулгуурлан бичээсийн агуулгыг сэргээн ойлгох боломжтой ажээ.

Өгүүлэн бүхий буюу Инэл уулын бэлд хаднаа сийлсэн бичээсийн хэв дардасыг уг бичээсийн шаштирт буй эхтэй харгуулан тулгаж үзэхэд 今 аялга үгээс бусад ханз үсэг төдий л зөрүүгүй байсан болно. Тиймээс шаштирын эхэд тулгуурлан монгол хэлнээ орчуулж судалгааны эргэлтэд оруулахыг хичээлээ. Алдаа эндэл буй аваас номын мэргэд нягталж магадлана гэдэгт гүнээ найдна.

Янь Рань уулын бичээс, орчуулга

Баруун илгэний хаднаа сийлсэн “Янь Рань уулын бичээс” хэмээн түүхэнд тэмдэглэгдсэн уг бичээс он цагийн уртад эх газрын эрс тэс уур амьсгал, олон жилийн нар салхинд элэгдэн бүдгэрч, зарим хэсэг ханз баларч эвдэрчээ.

Түүхэн бичмэл сурвалжид уг бичээс нийтдээ 296 орчим ханзаар тэмдэглэгдсэн байгаа бол, Баруун илгэний бичээсийн 80 орчим ханзыг шууд, харин 120 гаруй ханзыг бичээсийн хэв дардас, гэрэл зураг, бичлэг зэрэгт тулгуурлаж тодруулан унших боломжтой байна. Ялангуяа төгсгөл хэсгийн ханз одоо ч нэн тодорхой хэвээр.

Янь Рань уулын бичээсийн сурвалжид буй эхэд тулгуурласан монгол орчуулгыг толилуулахын өмнө, түүхэн сурвалжуудад уг нэртэй ойролцоо газрууд хэрхэн тэмдэглэгдсэн хийгээд үгийн талаар цухас боловч өгүүлэх нь зүйтэй болов уу.

Хүннүгийн газар нутаг байсан ой модтой, үзэсгэлэнт сайхан нэгэн уулын нэрийг хятадын түүхэн сурвалжид 閼氏山 (yan zhi shan), 燕支山(yan zhi shan), 焉支山 (yan zhi shan), 焉脂山(yan zhi shan), 刪丹山 (shan dan shan), 燕脂山(yan zhi shan), 胭脂山

(yan zhi shan) гэх зэргээр өөр өөр ханзаар тэмдэглэж бичсэн байдаг. Хүннүтэй олон удаа байлдсаны эцэст Хан улсын жанжин Хуо чюй бин (Huo qu bing) эзэлж авсан бөгөөд Хүннү нар тэр үзэсгэлэнт сайхан уулаа алдсандаа харамсаж “Тэнгэр уулаа алдлаа, зургаан хошуу мал минь өсөхөө болив, Янь жы (yan zhi) уулаа алдлаа, охид хүүхнүүд минь өнгө гэрэлгүй болов” гэж гашуудан дуулсан тухай сурвалжуудад тэмдэглэсэн нь бий. Уулын нэрийг нэг ханзаар бус, өөр өөр ханзаар тэмдэглэсэн байх төдийгүй тэдгээр ханз хятад хэлнээ ямар нэгэн утга илэрхийлдэггүй байна. Тиймээс эрдэмтэд уг уулын нэрийг “энгэсэг” хэмээх хүннү үгээс гаралтай бөгөөд Янь жы шань (yan zhi shan) нь энгэсэг их ургадаг, “Энгэсэгт уул” гэсэн утгатай нэр хэмээн үзсэн байдаг. Уг уул одоогийн БНХАУ-ын Ганьсу мужийн Шань дань (shan dan) сумаас зүүн урагшаа 50 орчим км-т буй.

Түүнчлэн 閼氏 (yan zhi) гэх үгийн утгыг 1.Хүннүгийн шаньюн хатныг хэлнэ. 2. Нүүдэлчин аймгийн эзэн хааны хатныг хэлнэ. 3. Хятадын Хан улсын үеийн сумны нэр. 4.Уулын нэр гэж тайлбарласан буй.

Тан улсын Ян шы хэмээгчээс “Хан улсын бичгийн зүүлт”-дээ “Ян зи бол Хүннүгийн хуанди (Хүннүгийн шаньюг хятадын хуанди-тай адилтгаж)-ийн хатны цол болно” (颜师古 《汉书注》曰: “閼氏, 匈奴皇后号也。” гэжээ. Тан улсын Сы ма жэнь (si ma zhen) хэмээгчээс “Хайлт зүүлт”-дээ “Хүннүгийн хуандигийн хатны цол болно”(司马贞 《索隐》亦曰: “(閼氏) 匈奴皇后号也”) гэжээ. Хятадын түүхэн сурвалжид бас “母閼氏”、“大閼氏” гэх үг тохиолддоогоос 母閼氏 нь шаньюгийн ээжийг зааж буй, харин 大閼氏 нь шаньюгийн их хатныг хэлж байна гэж эрдэмтэд үзжээ.

Дээрх баримтуудаас үзэхэд Хан улсын үеийн 閼 (yan) ханз хүннү хэлний *en, in; ej, ij язгуур махбодийг тэмдэглэсэн байж болохоор байна.

Үүнд тулгуурлан (yan ran) гэх ханзны хүннү нэр, үгийг сэргээн үзвэл *inilen~inelen гэсэн хэлбэртэй байсан нь түүхэн хөгжлийн явцад ~ inäl, inil болж хувирсан байж болох юм. Хэрвээ ийн үзвэл, Хүннүгийн *inilen~inelen гэх уулын нэрийн эхний үеийн in-ийг yan, харин хоёр дахь үеийн -len-ийг ran гэж ханз дуудлагаар (*inilen ~ inelen= yan ran) тэмдэглэсэн байх боломжтой.

Хэрвээ тийн үзвээс, Янь Рань хэмээсэн нь хятад дуудлагаар тэмдэглэгдсэн язгуур хүннү нэр байж болох ажээ.

Баруун илгэний бичээсийг сурвалжид буй эхээс сийрүүлбэл:

惟永元元年秋七月，有汉元舅曰车骑将军窦宪，寅亮圣明，登翼王室，纳于大麓，维清缉熙。乃与执金吾耿秉，述职巡御。理兵于朔方。鹰扬之校，螭虎之士，爰该六师，暨南单于、东胡乌桓、西戎氐羌，侯王君长之群，骁骑三万。元戎轻武，长毂四分，云輜蔽路，万有三千余乘。勒以八阵，莅以威神，玄甲耀目，朱旗绛天。遂陵高阙，下鸡鹿，经碛卤，绝大漠，斩温禺以衅鼓，血尸逐以染镆。然后四校横徂，星流彗扫，萧条万里，野无遗寇。于是域灭区殫，反旆而旋，考传验图，穷览其山川。遂逾涿邪，跨安侯，乘燕然，蹶冒顿之区落，焚老上之龙庭。上以搃高、文之宿愤，光祖宗之玄灵；下以安固后嗣，恢拓境宇，振大汉之天声。兹所谓一劳而久逸，暂费而永宁者也，乃遂封山刊石，昭铭盛德。其辞曰：

铄王师兮征荒裔，
剿凶虐兮截海外。
夙其邈兮亘地界，
封神丘兮建隆嵴，
熙帝载兮振万世！

Янь Рань уулын бичээсийн монгол орчуулга:

Юун юаний анхдугаар оны намрын долоон сар. Хан Юан үеийн улсын нагац, Чө Чи жанжин Дөү Шянь хэмээгч ариухан эгзээн байлаа. Тэнгэрийн хөвүүнийг хичээн хүндэлж, Вангийн ордныг туслан тэтгэж, хамаг олныг удирдаж, улсын хэргийг цэгцлэв.

Жы Жинь Ү түшмэл Гөн Бинтэй хамтдаа үүрэг хүлээж (хилийг) шалган байцаав.

Хойт газар цэрэг мордов. Бүргэд мэт Шяо түшмэлүүдтэй, луу, бар мэт байлдагчидтай байлаа. Зургаан замын цэрэг бүгд бэлэн болов. Бас Өмнөд Шань юй, зүүн Ухуань, Баруун Рун-гийн Ди Чян, Хөү Ван эзэн ахлагч мэтийн олны хүчтэй морьт дайчид гурван түмэн байлаа. Дайны тэрэг жирэлзэн, дайчид дөрвөн зүгт довтолгоно. Ачаа хөсөг зам хааж (боож), түмэн гурван мянга илүү байлаа. Найман жагсаалыг удирдаж, их сүрийг бадруулав. Хөө хуяг наранд гялс хийнэ. Улаан далбаа тэнгэрийг халхална. Тэгээд Гао Лань-д гарав. Жи Лү-д

буув. Элс хайргыг туулж, их цөлийг гэтлэв. Вэнь Юй-г цавчиж, хэнгэргээ тахив. Шы Жу-гийн цусаар сэлмийнхээ ирийг мялаав. Дараа нь дөрвөн шяо түшмэд дур зоргоор (эрх дураар) болов.

Тэнгэр булхаж од орчив.

Түмэн газрыг хоослов.

Тэнүүл дээрэмгүй болов.

Тэгээд газар нутгийг нь дуусган шавхав.

Тугаа буцаан эргүүлж, ялалтаар буцав.

Огоот санааг нь нягталж, уул усыг нь үлдээлгүй тойров. Жуо Е уулыг давав. Ань хөү голыг гатлав. Янь Рань ууланд гарав (үгч: Жуо Е-г давав. Ань хөү алхав. Янь Рань-д [эзэн]суув). Мо Дунь (Модун)-гийн аймгийг гишгэв. Лао Шан-ийн луу-гийн ордныг галдав.

Урьдын Гао, Вэнь-гийн бэтгэрсэн (хурсан) хилэнг гаргав, өвөг дээдсийн ариун сүнсийг гийгүүлэв. Хойшоо хойч үеийг амаржуулан тогтоов. Газар нутгаа тэлж, их Хан улсын нэр сүрийг дуурсгав. Энэ бөгөөс гагц зовох өнөдийн тайван, агишинаа зүдэх үүрдийн амгалан хэмээгч болой. Тэгээд уулыг тахиж, хаданд сийлэв. Тод (тодорхой) бичээсээр ёсыг дэлгэрүүлэв.

Тэр бичээсэнд:

Сүр хүчтэй Вангийн цэрэг зэрлэг бүдүүлгийг дайлав.

Сөргүү харгисыг устгаж харь гадныхныг хатгав.

Аглаг хязгаарт хүрч тэнгэрийн хаяанд тулав.

Ариун мандлыг тахиж, өндөр хөшөө бүтээв.

Ди (Хуанди)-г алдаршуулж, түмэн үед дуурсгав.

Зарим үгийн товч тайлбар:

1. 永元元年 (yong yuan yuan) Юун Юань Юань Зүүн Хан улсын Хө ди-гийн оны цол, нийт арван долоон жил хаан суужээ. Анхдугаар он нь нийтийн тооллын 89 он бөгөөд харин төгсгөл нь нийтийн тооллын 107 он болно.

2. 车骑将军 (chē qí jiāng jūn) Хан улсын үеийн хамгийн дээд тушаалтай цэргийн жанжин. Алтан тамгатай, тамганы бүч ягаан торгон. Эрх мэдэл нь их жанжин болон пиао чи жанжнаас дээгүүр байжээ.

3. 窦宪(dòu xiàn, ? —92 он) Зүүн Хан улсын алдартай жанжин, төрийн түшмэл болой. Охин дүү нь Зүүн Хан улсын үед Хань Жан Ди хааны хатан болжээ. Тиймээс дараагийн хаан, хаан суурь залгасны хойно энэ хүнийг улсын нагац гэж хүндэтгэж байжээ.

4. 汉元(hàn yuán) Зүүн Хан улсын анхдугаар

оны цолыг зааж буй.

5. 执金吾 (zhì jīn wú) Баруун Хан улсын сүүл үеэс шадар цэрэг удирдах, нийслэл хийгээд Хуанди-гийн ордныг хамгаалах цэргийн дарга нарыг ийн нэрлэж байжээ.

6. 耿秉 (gěng bǐng, ? — 91 он) Зүүн Хан улсын үеийн алдартай жанжин.

7. 朔方 (shuò fāng) Нэн эрт үеэс нангиадууд нүүдэлчдийн нутаглаж байсан хойт зүгийн газар нутгийг ийнхүү нэрлэж байжээ.

8. 六师 (liù shī) Жөү улсын тэнгэрийн хөвгүүний мэдэлд буй зургаан төрлийн цэргийг хэлдэг байжээ. Энэхүү бичээснээ олон замын цэрэг гэсэн утга зааж, илтгэж байгаа болно.

9. 八阵 (bā zhèn) Найман жагсаал нь хятадын эртний цэргийн байлдааны үеийн жагсаалын арга тактик. Чухам ямар арга, тактик байсныг өдгөө хүртэл бүрэн тогтоож, тодорхой болгосон нь хараахан үгүй бололтой.

10. 高阙 (gāo quē) Газрын нэр. Өдгөөх Өвөр Монголын Өөртөө Засах Орны Баяннуур аймгийн Хангин хойт хошууны баруун хойно буй газар мөн бололтой.

11. 鸡鹿 (jī lù) Жи Лу нь анх Зэн Гуаны 21 онд (647 он) Жи Лу боомтын хойт хэсэг нь Хангин хойт хошуу хүрч байжээ. Юн Хуйн анхдугаар он (650)-д Го Чуе-тэй нэгтгэгдээд Лу Жөү болгож, Кай юаны анхдугаар он (713)-д дахиад Лу Жөү болгожээ.

12. 温禺 (wēn yú) Хүннүгийн язгууртан, ихэсийг өргөмжилдөг цол.

13. 私渠比鞬海 (sī qú bǐ jiān hǎi) Сы чюй би ди хай нь Өмнөговь аймгийн нутагт орших Улаан нуур (талбай: 175 км², 13x14 км) мөн гэж үзнэ. Улаан нуурын талбайн хэмжээ хаврын сүүл, зуны эхэн саруудад цас борооны усаар сэлбэгдэн талбайн хэмжээ улам нэмэгддэг байна. 89 онд 6-р сар, 90 онд 5-р сар, 91 онд 2-р сард Хан улсын цэрэг Хүннүгийн эсрэг дайлаар мордсон нь санамсаргүй хэрэг биш, говийн халуунаас сэргийлж харьцангуй сэрүүн, тааламжтай цаг хугацааг сонгосонтой холбоотой биз ээ.

Бичээсийн түүхэн он цаг, ач холбогдол

Баруун илгэний бичээс Монгол нутгаас илэрч буй хамгийн эртний бичгийн дурсгалд зүй ёсоор тооцогдоно. Гагцхүү бичээсийг нийтийн тооллын 89 онд бичсэн үү, эсвээс 91 онд бичсэн үү гэдэг нь маргаантай байсаар. Жишээ нь, Зүүн Хан улс, Хүннүгийн дайнд оролцсон Дөү Шянь жанжны нэр, мөн

гуравдугаар он (нийтийн тооллын 91)-д болсон дайнд оролцсон Бань Гү нарын нэр цуг дурдагдаж байгаад үндэслэн хятадын эрдэмтэн Ли Бин Хай уг бичээсийг нийтийн тооллын 89 онд биш харин нийтийн тооллын 91 онд бичсэн байх боломжтой гэсэн санаа дэвшүүлсэн байдаг.

Тодруулбал, тэрбээр ““Бань Гү, уулыг тахисан бичээс”-д холбогдох баримт хийгээд бичээс сийлсэн он цагийг тодорхойлох нь” (李炳海, 2013 年第 2 期 北京) хэмээх өгүүлэлдээ, уг бичээснээ Зүүн Хан улс болон Хүннүгийн хоорондох дайныг нэг удаагийн байлдааны үйл явдлыг биш, харин гурван удаагийн байлдааныг хамтад нь тэмдэглэсэн буюу өөрөөр хэлбэл, Зүүн Хан улсын Хө ди-гийн Юун юань-ы анхдугаар он (和帝 永元元年), хоёр, гуравдугаар онд болсон гурван жилийн дайн тулааныг нэгтгэж бичсэн гэж үзэх болсон шалтгаанаа:

Нэгд, Дөү Шянь жанжин энэ гурван удаагийн дайнд гагц удаа буюу Юун юаний анхдугаар он (89)-д биеэр цэрэг удирдан мордсон. Тэрбээр Жи Луо 稽落 (jī luò) уулаар урагшлан Умард Хүннүг нэхэмжлэн цохиод зөвхөн Си чюй би ди хай 私渠比鞬海 (sī qú bǐ jiān hǎi) -д хүрсэн нь уулаас баруун өмнөдөд харьцангуй алс зайдуу байсан. Тиймээс Дөү Шянь жанжин ууланд гарч энэ бичээсийг сийлэх боломжгүй. Тэгээд ч Дөү Шянь жанжин удаах хоёр дайнд оролцоогүй, алсаас удирдсан байна.

Хоёрт, Юун юаний гуравдугаар он (91)-д Умард Хүннүг дайлах дайнд оролцсон бөгөөд ууланд гарч жанжин Гэн күй нарыг дайлсан. Өмнөх хоёр удаагийн дайнд оролцоогүй зэрэгт тулгуурлан тайлбарласан байна.

Хэдийгээр бичигдсэн он цагийг нарийвчлан тогтооход зарим зөрөө бий хэдий ч Баруун илгэний бичээс нь эртний бичгийн сурвалжийн хаданд сийлсэн хувилбар болохын хувьд шинжлэх ухааны үнэ цэнэтэй, биет хэрэглэгдэхүүн юм.

Хаднаа сийлсэн бичээсийн ханз, үг хэллэг нь түүхэн сурвалжийн ханз, үг хэллэгтэй үндсэндээ тохирч байгаад энэ дурсгалын гол онцлог, ач холбогдол оршихоос гадна газарзүйн байршлын мэдээллийг агуулсан биет өв, эртний түүхэн сурвалжийн үнэ цэнийг алдаршуулсан бодит дурсгал мөн юм. Бичээснээ “Жуо Е уулыг давав. Ань хөү голыг гатлав. Янь Рань ууланд гарав. Мо Ду (Модун)-гийн аймгийг гишгэв”

гэж буй. Уул давж, бас гол гатлаад ууланд хүрч байлджээ. Энд дурдагдаж буй Ань хөү гол бол Баруун илгэний баруунтаагуур 30 гаруй км-г урсан өнгөрөх эртний нэрээ хадгалж буй Онги гол (onggi) (onghu~onghi~onggi. 翁金河 Wēng jīn hé (Онги гол буюу Уэнг жин гол) болох нь лавтай. Онги гол нь Инэл уулын баруунтаах Онгийн хөндийгөөр урсан өнгөрөхдөө өмнөш говь руу 80 км үргэлжилж Улаан нуурт (13х14 км) цутгадаг. Говийн хамгийн их уст Улаан нуурыг байлдааны тэмдэглэлд Си чюй би ди хай 私渠比鞬海 (sī qú bǐ dī hǎi) буюу (海) “далай” хэмээсэн бололтой. Учир нь өнөөгийн Хатан мөрний Бортохойн баруун хойд бэхлэлтээс Хан улсын цэрэг умарш Янь Рань (Инэл буюу Дэлгэрхангай) хүртэл цэрэглэхэд тэдний замд тохиолдох хамгийн том нуур бол Улаан нуур юм.

Түүний өмнө Жуо Е уулыг давсан гэж буй нь Гурван сайхан уулыг заан нэрлэсэн

байж болох юм. Зарим судлаачид Жуо Е уулыг “өнөөгийн Өмнөговь аймгийн төв Даланзадгадын ойролцоох уул” гэж таамагласан нь үндэстэй.

Бортохой дахь баруун хойт бэхлэлт хотоос Янь Рань (Инэл) уул хүртэл Хан улсын цэргийн аян, замнал чиглэлтэй бидний сэргээж тогтоосон уул, гол, нуур үндсэндээ бүрэн тохирч буйг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Эцэст тэмдэглэхэд, Баруун илгэний бичээс нь Хан улсын цэргийн аян Умард Хүннүгийн зах хязгаар хүрээд буцсаныг гэрчилж байна. Тэд нутгийн гүнд цөмрөн орсонгүй. Өөрөөр хэлбэл, Онги голын (Ань хөү голын) доод урсгал дахь Инэл уулаас (Янь Рань уулаас) буцжээ. Ингэхлээр, Баруун илгэний хадны бичээс бол Зүүн Хан улсын цэрэг Хангай уул, Орхон голд хүрч (Умард Хүннүгийн төв нутагт нэвтэрч) их ялалт байгуулсан гэх түүхэн ташаа ойлголтуудыг залруулах нэгэн чухал сурвалж болж байна.

НОМ ЗҮЙ

Батжаргал Б., 2016. Хан улсын бичиг: Хүннүгийн шааштир. Улаанбаатар: Удам соёл.

Цэвэл, Я., 2013. Монгол хэлний товч тайлбар толь. Улаанбаатар.

李炳海. 2013 年第 2 期 北京. 班固《封燕然山铭》所涉故实及写作年代考辨. 文学遗产.

后汉书·窦宪传 第 03 册, 卷 23 卷; 南朝宋, 范晔编撰“唐”李贤等注“后汉书” 中华书局出版 1965 年 08 月

<https://www.lbrowncollection.com/atlas-of-china-jean-babtiste-danville-1732/>

中文: 一幅古代的地图从香港科技大学图书馆 (地圖中國 - 圖書館特藏展). 在书" China in European Maps", 香港, 2003.

In the Heart of Mongolia, 100th Anniversary of W. Kotwicz's Expedition to Mongolia in 1912, Studies and Selected Source Materials. Crakow 2012. ed. J. Tulisow, O. Inoue, A. Bareja-Starzynska, E. Dziurzynska

Qalqa-yin Tüšiyetü qan ayimaγ-un čiyulγan-u dede daruγ-a jasaγ ulus-un tüšiyе gün Ča-yin qošiγun-u nutuγ-un jiruγ. Badaraγultu törü-yin yučin yurbaduγar on tabun sarayin šine-yin yisün (1907). Газрын харилцаа, геодези зурагзүйн газрын архив. Түшээт хан аймаг.

SUMMARY

ANCIENT INSCRIPTION AT BARUUN ILGEN HILLS


TS. BATTULGA, G. BADAMSAMBUU, B. BATJARGAL

“Baruun ilgen” is hills with rock on top that lies to the southwest from the Delgerkhangai (Inel) mountain in the Gobi Desert, in the territory of Delgerkhangai soum, Dundgobi province. The name means “West visible”. An ancient Chinese inscription at the Baruun Ilgen hills of Mt. Delgerkhangai (Inel) was found in 2001 and studied comprehensively in June 2016.

In this paper, the authors present the results of the comparative studies of the inscription with other source materials, it's translation and description of some words and expressions mentioned in the script.

According to the studies the inscription at Baruun Ilgen hills is very similar with the written source of Han dynasty. This inscription is a significant textological source for the history of Xiongnu and Han dynasty as it cites the dates of the military battles between Han Dynasty and Xiongnu in 89-91 AD.

ХАВСРАЛТ



Зураг 1. Хүннүгийн газар нутаг дахь Инэл уулын байршил (МЭӨ II-МЭ I зуун)



Зураг 2. Түшээт Хан аймгийн гүн Чагдаржавын хошууны газрын зураг (1907 он). Энэ зурагт говирхог хээр ба говийн бүсийг өнгөөр ялгажээ.



Зураг 3. Хошууны газрын зурагт Инэл уулыг тэмдэглэсэн байдал



Зураг 4. Баруун илгэний ерөнхий байдал (Өмнө талаас. Бичээст хадыг сумаар заав)



Зураг 5. Баруун илгэний орой дахь бичээст хад (Өмнө талаас)



Зураг 6. Баруун илгэний бичээсийн байрлал. (Бичээс авч буй хүнтэй харьцуулсан байдал)



Зураг 7. Баруун илгэний бичээсийн дардас авч буй нь



Зураг 8. Хадан цохион өврийг тэгшилж засаад бичээс сийлсэн байдал



Зураг 9. Баруун илгэний бичээс ба түүний хуулбар

